

Нэр томьёоны мэдлэгийг үнэлэх

Олон сурагч, оюутнууд өөрсдийн сурсан зүйлийг хэрхэн үнэлэх талаар сайн мэдэж байдаг.

Тэд өөрсдийгөө юуг мэддэг, юуг сурах шаардлагатай байгаа талаар тодорхой мэдэж байдаг.

Энэхүү үнэлгээ нь нэгдүгээрт Аль ойлголт нь ангийн сурагчдад илүү хүндрэлтэй байгаа, хоёрдугаарт тухайн сурагч агуулгын аль хэсэгт бэрхшээлтэй учирч байгааг мэдэхэд багшид тусалдагаараа форматив үнэлгээний чухал хэрэгсэл болно.

Сурагчид дараах хэлбэрийн хүснэгтийг бөглөн өөрсдийн ойлголтыг тоон хэлбэрээр үнэлнэ.

Сэдэв: Магадлал, статистик				
Нэр томьёо	Хэзээ ч сонсож байгааг үй	Өмнө нь сонсож байсан	Мэддэг	Мэддэг бас тайлбар лаж чадна
Үзэгдэл				
Үзэгдлийн магадлал				
Үзэгдлийн давтамж				
Магадлалыг нэмэх дүрэм				
Үл хамаарах үзэгдэл				
Нөхцөлт магадлал				
Магадлалыг үржих дүрэм				
Хамаарах үзэгдэл				
Боломжгүй үзэгдэл				
Гарцаагүй үзэгдэл				
Нийт:	Он, сар, өдөр:			

Өөрийн үнэлгээ нь байнга хийж байдаг үнэлгээ учир дээрх үнэлгээг мөн тогтмол хугацаанд, үе шаттай хийж байвал үр дүнтэй. Энэ үнэлгээг нэг улирлын хувьд

- сэдэв эхлэхээс өмнө оюутнуудын анхны мэдлэгийг үнэлэх
- хичээлийн явцад оюутнууд ойлголтоо эзэмшиж байгаа эсэх, аль ойлголтыг судлахад хүндрэл гарч байгааг тогтоох
- хичээлийн төгсгөлд, төгсгөлийн шалгалтаас өмнө хичээлийн үр дүн, нөлөөг тодорхойлох зорилгоор дор хаяж гурван удаа хийх нь зүйтэй гэж зарим судлаачид үздэг.

Энэ аргыг хэрхэн хэрэглэх вэ?

1. Тухайн сэдвээр оюутан сурагчдын ихэвчлэн хэрэглэх 10-12 нэр томьёог сонгон авна. Бүх оюутан зайлшгүй мэддэг байх шаардлагатай үг, нэр томьёог л сонгоно.
2. Дээрх хүснэгтийг бүх оюутан, сурагчид тараан өгнө.
3. Оюутан, сурагчид хүснэгтийн бөглөн өөрсдийн нийт оноо болон он, сар, өдрийг тэмдэглэнэ.

4. Оюутан, сурагчид өөрсдийн бөглөсөн хүснэгтийг хэсэг хугацааны дараа эргэн харж мэдлэг, ойлголт хэрхэн нэмэгдэж, өөрчлөгдсөнийг шалгах боломж олгох.
5. Нэгж, улирлийн төгсгөлийн шалгалтанд бэлтгэхэд дээрх хүснэгтийг эргэн харж, ашиглах боломж оюутан, сурагчдад шалгалтандаа бэлтгэх боломж олгох.

Зарим сэдвийн түлхүүр үг.

- Олон өнцөгт: Зөв зургаан өнцөгт, зөв найман өнцөгт, параллелограм, зөв таван өнцөгт, олон өнцөгт, дөрвөн өнцөгт, тэгш өнцөгт, ромбо, квадрат, трапез, гурвалжин, диагональ, зөв олон өнцөгт, гүдгэр дүрс, гүдгэр биш дүрс.
- Тригонометр: нэгж тойрог, өнцгийн хэмжээ, градус, радиан хэмжээс, нумын урт, эргүүлэлт, Пи тоо, харьцаа, синус, косинус, тангенс
- Статистик: харйцаг ба сахалны диаграм, цэгэн график, өгөгдөл, дундаж, иш навчны диаграм, тоолох арга, варианс, эх олонлог, түүвэр, давтамж, тархалт
- Зэрэгт функц: зэрэгт функц, квадрат функц, хагас задрал, өсөлт, экспоненциал өсөлт, зэрэг, илтгэгч, экспоненциал буурлт, зэрэгийн чанарууд, шулууны налалт

Аргын зарим хувилбар

Definition doctor (Тодорхойлолтын доктор-эмч) Нэр томъёоны мэдлэгийн үнэлгээг тоглоом хэлбэрт оруулсан, форматив үнэлгээ хийх оновчтой санаа юм. Дараах алхмуудын дагуу тоглоно.

1. Бүх сурагчид НТМУ-ээ бэлтгэнэ.
2. Эхлээд багш Тодорхойлолтын эмч болох ба уг доктороос өөр сурагч НТМУ-с нэг үгийг сонгон тэр үгийн утга, тодорхойлолт холбогдох тайлбарыг асууна.
3. Дараа нь доктороо солин өөр сурагч болж үүргээ солин асуух маягаар үргэлжилнэ. Хэрэв сурагчид мэдэхгүй зүйл, хүндрэл гарвал өөр сурагчийн туслахаар томилж болно.
4. Бүх үгийг тодорхойлж, тайлбарлаж дуусах хүртэл тоглоомыг үргэлжлүүлнэ.
5. Багш тоглоомын явцад маш анхааралтай байж аль үг, тодорхойлолтыг мэдэхгүй байгаа, будилж байгаа, амжилттай тайлбарлаж байгааг тэмдэглэн сурагчдад фийдбак өгөх, нэмэлт тайлбар өгөх, туслагч сурагчийг сонгох зэргээр зохион байгуулна.